

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/11/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,  
Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цогбаяр  
Утас: 261628 Цахим хаяг: Tsogbayra@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Ариунжаргал  
Утас: 262071 Цахим хаяг: ariunjargalba@audit.gov.mn

Аудитор: Г.Өсөхжаргал  
Утас: 262071 Цахим хаяг: usukhjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АДЗ	Амьжиргаа дэмжих зөвлөл
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
СНАГ	Санхүү-Нийцлийн аудитын газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
СЯ	Сангийн яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 06/799  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн халамжийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу халамжийн сангаас 72 төрлийн 18 хөтөлбөрийн халамжийн үйлчилгээнд улсын төсвөөс 2,599,310 иргэнд 2,413,454.7 сая төгрөг, сангийн үйл ажиллагааны зардалд 267.8 сая төгрөг, нийт 2,413,722.5 сая төгрөгийг зарцуулжээ. Үүнээс 1,353,720 хүүхдэд нийт 1,549,749.2 сая төгрөгийг хүүхдийн мөнгөн тэтгэмжид олгосон нь нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн зардлын 64.2 хувийг эзэлж байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу 2022 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгоогүй хүүхдүүдэд нөхөн олгох шийдвэрийг Сангийн яамнаас гаргаж, нийгмийн халамжийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 486.4 сая төгрөгөөс зарцуулаагүй үлдэгдэл 84.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## Бусад асуудлын хэсэг

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газар нь 2025 оны төлөвлөгөөт хяналт шалгалтаар нийт 9 байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг гүйцэтгэж, хууль журмыг хэрэгжүүлэн ажиллах 38 зөвлөмж, 18.8 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 571.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон улсын төсвийн орлогод төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу 78 илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/ төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,603,200.00</b>	-
33	АВЛАГА	8,603,200.00	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	7,603,200.00	-
33500	Бусад авлага	1,000,000.00	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,000,000.00	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,603,200.00</b>	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,603,200.00</b>	-
51	Засгийн газрын оролцоо	8,603,200.00	-
51200	Хуримтлагдсан үр дүн	8,603,200.00	-
51210	Өмнөх үеийн үр дүн	8,603,200.00	-
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР,ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,603,200.00</b>	-

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/ төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,352,226,330,562.63	2,444,277,209,573.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	358,420,962.63	2,444,277,209,573.70
120	Нийтлэг татварын бус орлого	358,420,962.63	571,746,573.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	358,420,962.63	571,746,573.70
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	358,420,962.63	571,746,573.70
122	Тусламжийн орлого	-	2,443,705,463,000.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,443,705,463,000.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	2,443,219,103,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	2,443,219,103,000.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	486,360,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	486,360,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,351,867,909,600.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,351,867,909,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,351,867,909,600.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,352,226,330,562.63	2,444,277,209,573.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,352,226,330,562.63	2,444,277,209,573.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,131,157,907.49	267,880,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,116,630,007.49	267,880,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,106,630,007.49	267,880,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,527,900.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,527,900.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,351,095,172,655.14	2,444,009,329,473.70
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	29,848,585,996.06
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	29,848,585,996.06
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	29,848,585,996.06
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	29,764,425,996.06
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	84,160,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,299,000,426,655.54	2,413,588,996,903.94
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,299,000,426,655.54	2,413,588,996,903.94
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,094,745,999.60	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,772,759,686.97	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	321,986,312.63	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	571,746,573.70
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	571,746,573.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,352,246,456,696.63	2,444,277,209,573.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	366,147,096.63	2,444,277,209,573.70
120	Нийтлэг татварын бус орлого	366,147,096.63	571,746,573.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	359,010,962.63	571,746,573.70
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	359,010,962.63	571,746,573.70
120008	Төвлөрүүлэх шилжүүлэг (Устгал)	7,136,134.00	-
122	Тусламжийн орлого	-	2,443,705,463,000.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,443,705,463,000.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	2,443,219,103,000.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	2,443,219,103,000.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	486,360,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	486,360,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,351,880,309,600.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,351,867,909,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,351,867,909,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,400,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,400,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,352,246,456,696.63	2,444,277,209,573.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,352,246,456,696.63	2,444,277,209,573.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,138,294,041.49	267,880,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,123,766,141.49	267,880,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,113,766,141.49	267,880,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,527,900.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,527,900.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,351,108,162,655.14	2,444,009,329,473.70
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	29,848,585,996.06
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	29,848,585,996.06
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	29,848,585,996.06
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	29,764,425,996.06
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	-	84,160,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,299,013,416,655.54	2,413,588,996,903.94
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,299,013,416,655.54	2,413,588,996,903.94
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,094,745,999.60	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,772,759,686.97	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	321,986,312.63	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	571,746,573.70
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	571,746,573.70

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	32,193,200.00	32,193,200.00
2	Тайлант үеийн үр дүн	-	-	(23,590,000.00)	(23,590,000.00)
3	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	8,603,200.00	8,603,200.00
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
5	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
6	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,512,965,502,100.00	2,413,454,677,003.94	99,510,825,096.06	96.0
12	Татварын бус орлого	2,512,965,502,100.00	2,413,454,677,003.94	99,510,825,096.06	96.0
122	Тусламжийн орлого	2,512,965,502,100.00	2,413,454,677,003.94	99,510,825,096.06	96.0
122005	Төсвөөс санхүүжих	2,512,965,502,100.00	2,413,454,677,003.94	99,510,825,096.06	96.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,512,965,502,100.00	2,413,454,677,003.94	99,510,825,096.06	96.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,512,965,502,100.00	2,413,454,677,003.94	99,510,825,096.06	96.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	295,615,100.00	267,880,100.00	27,735,000.00	90.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	295,615,100.00	267,880,100.00	27,735,000.00	90.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	267,880,100.00	267,880,100.00	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	27,735,000.00	-	27,735,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,512,669,887,000.00	2,413,186,796,903.94	99,483,090,096.06	96.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,512,669,887,000.00	2,413,186,796,903.94	99,483,090,096.06	96.0
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,512,669,887,000.00	2,413,186,796,903.94	99,483,090,096.06	96.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-

## 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	486,360,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	486,360,000.00
122	Тусламжийн орлого	486,360,000.00
1221	Хандив тусламж /дотоод/	486,360,000.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	486,360,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	486,360,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	402,200,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	402,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	402,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	402,200,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	402,200,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	84,160,000.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(84,160,000.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(84,160,000.00)

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааны зорилго нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй, чанартай хүргэхэд оршино.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийн зорилтын хүрээнд хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлын түвшнийг бууруулах дараах чиг үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

- Халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах;
- Төрд байгаа иргэний мэдээллийг иргэнээс шаардахгүйгээр нийгмийн халамжийн үйлчилгээ, арга хэмжээнд хамруулах, түргэн шуурхай хүргэх, халамжийн нэгдсэн систем /ehalamj.mn/ цахим системийг нэвтрүүлж, үйлчилгээний менежментийг сайжруулах; Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээтэй холбоотой иргэний өргөдөл гомдлыг цаг хугацаанд нь хууль журмын дагуу шийдвэрлэх;

Нийгмийн халамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Нийгмийн халамжийн үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр;
- Нийгмийн халамжийн тэтгэмж;
- Нийгмийн халамжийн үйлчилгээ;
- Нийгмийн хөгжлийн үйлчилгээ.

Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагаа нь Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль, Тайгад амьдардаг цаатан иргэнд тэтгэмж олгох журам болон салбарын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актаар зохицуулагдаж байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд дараах нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлж байна.

- Халамжийн тэтгэвэр;
- Асаргааны тэтгэмж;
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж;
- Хүүхдийн мөнгөн тэтгэмж;
- Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж;
- Асрамжийн үйлчилгээ;
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ;
- Ахмад настанд үзүүлэх шинэ төрлийн үйлчилгээ;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж хөнгөлөлт;
- Насны хишиг;
- Эхийн алдар одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламж.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж болон бодлого, чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;

- Засгийн газрын 2025 оны “Журам шинэчлэн батлах тухай” 117 дугаар тогтоолын хавсралтаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж хөнгөлөлт олгох журам”;
- Засгийн газрын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” 243 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар “ахмадын сан байгуулан ажиллах журам” /2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн/;
- Засгийн газрын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” 244 дүгээр тогтоолоор “Насны хишиг олгох журам журам” /2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн/;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавар, 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

ХХҮЕГ-ын Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газар нь 2025 оны төлөвлөгөөт хяналт шалгалтаар нийт 9 байгууллагын /Баянхонгор, Дундговь, Орхон, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгуудын ХХҮГ болон Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдийн ХХҮГ, Нийгмийн халамжийн сан/ үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг гүйцэтгэн, 18.8 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, зөрчил арилгах 38 хугацаатай зөвлөмжийг өгсөн байна. Хяналт шалгалт, дотоод аудит, мониторингийн газрын шалгалтаар дараах нийтлэг зөрчлийг илрүүлжээ. Үүнд:

- Протез, ортопедийн хэрэгслийг хос эрхтэнд хийлгэсэн тохиолдолд дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлэг хяналтын комиссын шийдвэрүүд үнэн бодитой эсэхийг нягтлан шалгаагүй;
- Ортопедийн болон тусгай хэрэгсэл шаардлагатай тухай эмчийн тодорхойлолтын хугацаа /он, сар, өдөр/ тусгай хэрэгсэл нийлүүлэгч байгууллагад мөнгө төлсөн баримт, нэхэмжлэхийн хугацаанаас хойш гарч байгаад хяналт тавиагүй, эмнэлгийн байгууллагын тодорхойлолтыг нөхөн гаргасан эсэхийг нягтлан шалгаагүй;
- Нэхэмжлэхэд бичигдсэн протез, ортопед, тусгай хэрэгслийг оноосон нэрээр бус ерөнхий нэрээр бичиж, зарлагын баримт үүсгүүлсэн зэрэг зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг өгсөн байна.

Үүнээс гадна нийгмийн халамжийн сангаас олгож буй “цалинтай ээж” хөтөлбөрийн хэрэгжилтэд төлөвлөгөөт бус болон эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг гүйцэтгэсэн байна.

Аудитаар илрүүлсэн зөрчлийн биелэлтийг шалгагдагч байгууллагаас Хяналт-шалгалт, дотоод аудит, мониторингийн газарт ирүүлсэн тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил, гүйлгээг аккрузул сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь ХХҮЕГ-ын 2024 оны А/384 дүгээр тушаалаар батлагдсан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монгол Улсын Сангийн Сайдын тушаалаар баталсан журам, заавар, аргачлалын дагуу шинэчлэн батлаагүй байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	8,603.2	-	(8,603.2)
Нийт хөрөнгө	8,603.2	-	(8,603.2)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	8,603.2	-	(8,603.2)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>8,603.2</b>	<b>-</b>	<b>(8,603.2)</b>

Тайлант онд хувь хүмүүсээс авах 1.0 сая төгрөгийн авлага, Налайх дүүргийн ХХҮХ-ийн илүү олгосон төлбөртэй үйлчилгээний 7.6 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 8.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны санхүүгийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Нийгмийн халамжийн сангийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,636,555.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид 2024 оны 01/1025 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

Нийгмийн халамжийн сангийн зардалд төлөвлөсөн амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал 117,502.5 сая төгрөгийг хасаж, нийт 2,519,052.7 сая төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Тайлант онд батлагдсан төсвөөс үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 153.1 сая төгрөгийг хасаж, нийгмийн халамжийн сангийн зардлыг 6,229.8 сая төгрөгөөр бууруулан, 2,512,669.8 сая төгрөгөөр тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 17 арга хэмжээг улсын төсвөөс 2,512,669.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 2,443,219.1 сая төгрөгийн санхүүжилтийг авч, өөрийн орлогоор 571.7 сая төгрөг, нийт 2,444,277.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэлээр 2,413,454.7 сая төгрөгийг зарцуулж, өөрийн орлогоос 571.7 сая төгрөг, зарцуулаагүй үлдэгдлээс 29,764.4 сая төгрөг, нийт 30,420.3 сая төгрөгийг улсын төсөв буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,413,454.7 сая төгрөг буюу 96.0 хувьтай байгаа нь халамжийн тэтгэврийг 4,760.66 сая төгрөгөөр, асаргааны тэтгэмжийг 2,385.4 сая төгрөгөөр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 6,492.2 сая төгрөгөөр, ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлтийн зардлаас 1,041.9 сая төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 3,112.2 сая төгрөг, ХБИ-ий хөнгөлөлт

Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

тусламжийн зардлыг 936.9 сая төгрөг, алдарт эхийн одонтой эхэд олгох тэтгэмжийн зардлыг 274.1 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний нэр		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Бие-лэлт /хувь/
1	Код	Нийт дүн	2,443,219,103.00	2,413,454,677.00	29,764,426.11	97.8
1.1	213203	Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	1,417,879.30	1,417,879.30	-	100.0
1.2	213203	Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	38,402,713.30	37,360,583.42	1,042,130.00	97.2
1.3	213203	Алдарт эхийн одонтой эхэд олгосон мөнгөн тэтгэмж	66,297,490.00	66,023,370.00	274,120.00	99.5
1.4	213203	Насны хишиг	30,637,060.00	30,577,190.00	59,870.00	99.8
1.5	213203	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	1,552,861,311.00	1,549,749,211.00	3,112,100.00	99.8
1.6	213203	Хүүхэд асарсны тэтгэмж	71,775,818.90	67,043,658.48	4,732,160.42	81.2
1.7	213203	Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	22,970,263.50	22,966,716.73	3,546.77	99.9
1.8	210801	Бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг бараа ажил үйлчилгээ	267,880.20	267,880.10	0.10	100.0
1.9	213203	Халамжийн тэтгэвэр	282,193,175.50	277,432,508.26	4,760,667.24	98.3
1.10	213203	Асаргааны тэтгэмж	252,759,827.00	250,374,414.27	2,385,412.73	99.0
1.11	213203	Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	83,479,308.50	76,987,117.14	6,492,191.36	92.2
1.12	213203	Жирэмсэн эхийн тэтгэмж	8,676,203.60	8,125,092.33	551,111.27	93.6
1.13	213203	ХБИ-д үзүүлэх тусламж, хөнгөлөлт	13,307,684.90	12,370,893.52	936,791.38	92.9
1.14	213203	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	16,851,487.3	11,439,162.46	5,412,324.84	67.8
1.15	213203	Ихэр хүүхдийн тэтгэмж	1,321,000.00	1,319,000.00	2,000.00	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Аймаг, нийслэлийн төсвөөс нийгмийн халамжийн санд олгосон санхүүжилтийн талаар:**

Аймаг, нийслэлийн төсвөөс нийгмийн халамжийн санд нийт 6,438.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 2,984.6 сая төгрөг, цаатан иргэдийн тэтгэмжид 1,966.3 сая төгрөг, онцгой тохиолдлын тэтгэмжид 1,409.7 сая төгрөг, төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд 63.6 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 14.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг тухайн орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан болно.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Тэтгэмжийн төрөл	Хүний тоо	Гүйцэтгэл
1	Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх	776	933,600.0
2	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	250	301,200.0
3	Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн	116	139,200.0
4	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эх	27	35,683.2
5	Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ /орон нутгийн төсөв/	40	63,593.7

6	Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах	2,083	378,752.8
7	Зөвлөгөө өгөх	454	71,031.0
8	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	245	64,380.0
9	Түр байршуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах	49	39,803.9
10	Өдрийн үйлчилгээнд хамруулах	1,156	71,951.5
11	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	543	138,535.4
12	Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах	1,054	941,016.5
13	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2, 18.2.-т заасан өрх иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах	1,835	1,083,946.3
14	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд хамруулах	69	58,183.9
15	Иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ	1,628	137,022.5
<b>16</b>	<b>Цаатан иргэдийн тэтгэмжид</b>	<b>381</b>	<b>1,966,346.9</b>
16.1	Насанд хүрсэн иргэн	223	1,456,260.0
16.2	Хүүхэд	158	510,086.9
17	Үйл ажиллагааны зардал /орон нутаг/	-	14,250.0
<b>ДҮН</b>		<b>10,706</b>	<b>6,438,497.9</b>

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу 2022 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгоогүй хүүхдүүдэд нөхөн олгох шийдвэрийг Сангийн яамнаас гаргаж, нийгмийн халамжийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансаар 486.4 сая төгрөгийг олгохоор төлөвлөснөөс 402.2 сая төгрөгийг олгож, зарцуулаагүй үлдэгдэл 84.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Нийгмийн халамжийн сангийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 1 багц бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад нийт 1,707.6 сая төгрөгийн төсвийг баталжээ.

Тайлант онд төсвийн үйл ажиллагааны худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөө, жагсаалтад өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,725.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Нийгмийн халамжийн сан, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн сангийн хөрөнгийг зохистой удирдах, төсвийн хэмнэлт, дотоод хяналттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Өсөхжаргал гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг ахлах аудитор Б.Ариунжаргал, дараагийн шатны хяналтыг аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн халамжийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/382 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,352,226.3 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 23,522.3 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэх үе шатанд дахин хянаад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан горим сорил хэрэгжүүллээ. Санхүүгийн тайлангийн аудитаар нийгмийн халамжийн сан нь 6.2 сая төгрөгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэлгүй зарцуулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 215,625.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 215,466.4 сая төгрөгийн 1 зөрчилд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага, НББ-тэй холбоотой 1 зөрчилд албан шаардлага, 159.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 4,688.8 сая төгрөгийн 14 гүйлгээ, орлогын 210,777.5 сая төгрөгийн 13 гүйлгээг хугацаа хоцроон байршуулж, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжээгүй, зөрчил давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:", 3.1.1-д "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд;", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" заалтуудыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөрчил арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар бусад хууль тогтоомжийн хүрээнд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийгмийн халамжийн үйлчилгээг төрөл бүрээр нь зардалд бүртгэж, тайлагнахаар заасны дагуу ерөнхий журналыг хөтөлсөн боловч мөнгөн гүйлгээний журналд халамжийн гүйлгээг багцаар нь хийж, хөтөлбөр тус бүрээр тайлагнасан байна. Энэ нь халамжийн сангийн үйлчилгээ нь үйлчилгээ тус бүрээрээ зориулалтын дагуу зарцуулагдаж буй эсэхийг хянах боломжгүй, зардал хооронд шилжүүлэн зарцуулсан байх эрсдэлтэй байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн тайлагнана", Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2024 оны А/384 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан "Халамжийн сангийн дансны жагсаалт"-тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн гүйлгээний журналыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу хөтлөөгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

2. Хүүхдийн мөнгөн тэтгэмжээс e-halamj системээр "хүүхдийн төлөө сан"-д хандив өгөхөөр хүсэлт гаргасан иргэдийн 159.0 сая төгрөгийн мэдээллийг журамд заасны дагуу ил тод мэдээлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны "Журам шинэчлэн батлах тухай" 236 дугаар тогтоолоор баталсан "Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам"-ын 3.7-д "Хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор Хүүхдийн төлөө санд хүүхдийн мөнгөө шилжүүлсэн талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олон нийтэд мэдээлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: E-halamj системээр "Хүүхдийн төлөө сан"-д хандив өргөхөөр хүсэлт өгсөн иргэдийн мэдээллийг хүний тоо болон хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нийт дүнгээр байгууллагын цахим хуудсанд мэдээлж хэвших.

3. ХХҮЕГ-ын даргын 2025 оны "Ахмад настанд амралт, сувиллын үйлчилгээ үзүүлэх байгууллагын жагсаалт батлах тухай" А/223 дугаар тушаалын дагуу 24 сувиллын газар, 28 амралтын газартай 2025 оны 06 дугаар сараас 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд гэрээ байгуулж гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байна. ХХҮЕГ-ын даргын 2026 оны 02 дугаар сарын А/52 дугаар тушаалаар 2026 онд ахмад настанд үйлчилгээ үзүүлэх амралт САГ-2026/11/НА-СТА-ЗГТС

сувиллын газрын жагсаалтыг батлахдаа гэрээ байгуулсан 4 амралтын газар, 5 сувиллын газрыг жагсаалтаас хасаж баталсан нь гэрээний үүрэг зөрчигдөх, талуудын дунд маргаан үүсэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн тайлагнана", ХХҮЕГ-ын даргын 2024 оны А/384 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан "Халамжийн сангийн дансны жагсаалт"-тай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** ХХҮЕГ-ын дарга нь "Ахмад настанд амралт сувиллын үйлчилгээ үзүүлэх байгууллагын жагсаалт"-ыг тайлант оны эхэнд батлах, амралтын болон сувиллын газруудтай 2 он дамжуулж гэрээ байгуулахгүй байх

4. Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааны зардлын төсөвт хяналт шалгалтыг орон нутгийн түвшинд хийхэд шаардагдах дотоод томилолтын зардлыг батлаагүй нь халамжийн хөтөлбөр зорилтот бүлэгт хүрч байгаа эсэхэд Төрийн захиргааны байгууллагаас тавих хяналт алдагдах эрсдэлтэй байна.

Энэ нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8-д "Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамжийн үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, тэтгэвэр, тэтгэмжийн олголт, үйлчилгээний чанар хүртээмж болон халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүрэг бүхий хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжтэй байна.", Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д "Төрийн албан хаагчид дараах нөхөх төлбөрийг олгоно:", 59.1.1-д "албан томилолтын зардлыг;" ХХҮЕГ-ын стратегийн зорилтод заасан "хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагналтыг ил тод нээлттэй болгож, хяналтыг сайжруулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааны зардалд дотоод томилолтын зардлыг төлөвлөн батлуулж, нийгмийн халамжийн үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, тэтгэвэр, тэтгэмжийн олголт, үйлчилгээний чанар хүртээмж болон халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн, тайлагнаж хэвших.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Нийгмийн халамжийн сангийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар 1,971.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 264.0 сая төгрөгийн зөрчлийг арилгахаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1,707.6 сая төгрөгийн зөрчлийг арилгаагүй тул жилийн эцсийн аудитаар зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 9,365.3 сая төгрөгийн 8 албан шаардлагаас 9,357.7 сая төгрөгийн 7 албан шаардлагыг хэрэгжүүлж, хэрэгжилт 99.1 хувьтай байна.

Хүснэгт 4. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	1,992,851,027.2	3	1,777,225,631.6	89.1
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>1,992,851,027.2</b>	<b>3</b>	<b>1,777,225,631.6</b>	<b>89.1</b>

Өмнөх аудитаар өгсөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлагын биелэлт хангалтгүй байгаа тул сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд олгодог санхүүжилт, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгодог тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлт, ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн санхүүжилтийн зарцуулалтад цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл байдал, хамрах хүрээнээс шалтгаалан хангалттай зохистой нотолгоо олж авах боломжгүй байсан тул түүврийн нарийвчилсан горим сорилыг анхан шатны нэгж, байгууллагуудад хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.2 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд:

### Залруулсан алдаа:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжийн зардлыг 0.2 сая төгрөгөөр илүү, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжийн зардлыг 0.2 сая төгрөгөөр дутуу, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 0.1 сая төгрөгөөр илүү тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжийн зардлыг 0.7 сая төгрөгөөр илүү, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжийн зардлыг 0.7 сая төгрөгөөр дутуу, асаргааны тэтгэмжийг 0.2 сая төгрөгөөр илүү, жирэмсэн эхэд олгох тэтгэмжийг 0.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.

Эдгээр алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэж заасантай тус тус нийцэхгүй, УСННОУС-1 санхүүгийн тайлангийн толилуулгын 1.27, УСНББОУС-17 үндсэн хөрөнгийн 17.42 дахь параграф, санхүүгийн аудитын "оршин байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 1,978.7 сая төгрөгийн 5 зөрчил<sup>1</sup> илэрснээс 1,809.6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,978.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 21,543.6 сая төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

### 5.1 Албан шаардлага

5.1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх 1,707.6 сая төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалтыг зарлахдаа тендерийн баримт бичгийн жишиг шаардлагыг мөрдөөгүй, тендерийн баримт бичигт санхүүгийн чадамжийг "шаардахгүй" гэж тусган худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан заалтуудтай нийцэхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д "тендер шалгаруулалтын баримт бичиг" гэж захиалагчаас тендер шалгаруулалтын нөхцөл, шаардлага, аргачлалыг тодорхойлсон баримт бичгийг;", 15 дугаар зүйлийн 15.1-д "Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.", 16 дугаар зүйл "Санхүүгийн чадавхын шаардлага:" 16.1-16.6, 26 дугаар зүйлийн 26.4-т Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэх эсэхийг дараах байдлаар хянан үзнэ: 26.4.1-д "энэ хуулийн 15, 16, 17 дугаар зүйлд заасан чадавхын болон туршлагын доод шаардлагыг хангасан байх;", Сангийн сайдын 2025 оны "тендер шалгаруулалтын жишиг баримт шинэчлэн батлах тухай" А/103 дугаар тушаалын хавсралтын 18-д "Чадавхын болон туршлагын шаардлага", 18.1-д "Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн

хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална." гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн баримт бичгийг хуульд заасны дагуу боловсруулдаггүй, холбогдох хуулийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу 2022 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгоогүй хүүхдүүдэд нөхөн олгох шийдвэрийг Сангийн яамнаас гаргаж, нийгмийн халамжийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансаар 486.4 сая төгрөгийг олгосноос зарцуулаагүй үлдэгдэл 84.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн боловч Сангийн яамны Төрийн сангийн газартай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэлт санхүүжилтийн данснаас улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Санхүү, төсвийн асуудал хариуцсан байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулдаггүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, системийн хөгжүүлэлт хийхэд 17.8 сая төгрөгийг зарцуулж, шууд зардалд бүртгэсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1.1-т "энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 6.1-д "аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар бүртгэнэ." гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулалгүй худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1.Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Аймаг, дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний газар, хэлтсүүдэд өрхийн судалгааны 162.8 сая төгрөгийн санхүүжилтийг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэн, олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 6.1-д "аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар бүртгэнэ.", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг бараа материалын болон тооцооны дансаар дамжуулан бүртгэж, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрөх, нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын дагуу хөтлөх.

Илрүүлэлт 2: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "ажлын даалгавар, зардлын төсөв батлах тухай" А/430 дугаар тушаалаар Халамжийн сангийн үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх, байгууллагын үйл ажиллагаа үйлчилгээний талаар иргэд, олон нийтэд ил тод мэдээлэх сурталчлах, түгээх, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн танилцуулга бүхий контент бэлтгэх ажилд 6.2 сая төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;" Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" 05 дугаар албан даалгаврын 1.4.4-т "гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ шинээр байгуулахгүй байх" гэж заасныг тус тус зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн сахилга батыг чангатгаж, хууль журамд зөвшөөрөгдөөгүй зардал гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжийн зардлыг 159.8 мянган төгрөгөөр илүү, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжийн зардлыг 159.8 мянган төгрөгөөр дутуу, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 100.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	259.8			1	259.8	1	259.8				
Санхүүгийн үр дүнгийн тайланд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийн хөнгөлөлт тусламжийн зардлыг 750.0 мянган төгрөгөөр илүү, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжийн зардлыг 750.0 мянган төгрөгөөр дутуу, асаргааны тэтгэмжийг 240.0 мянган төгрөгөөр илүү, жирэмсэн эхэд олгох тэтгэмжийг 240.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	990.0			1	990.0	1	990.0				
<b>Нийт</b>	<b>2</b>	<b>1,249.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>1,249.8</b>	<b>2</b>	<b>1,249.8</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

6.2. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Хүний тоо	Дүн	Тоо	Дүн
"Ирээдүйн өв сангийн тухай хууль"-ийн дагуу 2022 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгоогүй хүүхдүүдэд мөнгөн тэтгэмжийг нөхөн олгох шийдвэрийг Сангийн яамнаас гаргаж, нийгмийн халамжийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансаар 486,360.0 мянган төгрөгийг олгож зарцуулсан байна. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зарцуулаагүй үлдэгдэл 84,160.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн ч Сангийн яамны төрийн сангийн газартай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	84,160.0			1	84,160.0							
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, системийн хөгжүүлэлт хийхэд 17,800.0 мянган төгрөгийг зарцуулж, шууд зардалд бүртгэсэн.	1	17,800.0			1	17,800.0							
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх 1,707,642.3 мянган төгрөгийн нээлттэй тендер зарлахдаа тендерийн баримт бичгийн жишиг шаардлагыг мөрдөөгүй, тендерийн баримт бичигт санхүүгийн чадамжийг "шаардахгүй" гэж тусгаж худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан заалтуудтай нийцэхгүй байна.	1	1,707,642.3			1	1,707,642.3							
Аймаг, дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний газар, хэлтсүүдэд өрхийн судалгааны 162,880.1 мянган төгрөгийн санхүүжилтийг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэн, олгосон байна.	1	162,880.1					1	162,880.1					

Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Төсвийн сахилга бат хариуцлагыг чангатгах тухай" 05 дугаар албан даалгавар, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн "ажлын даалгавар, зардлын төсөв батлах тухай" А/430 дугаар тушаалаар Халамжийн сангийн үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх, байгууллагын үйл ажиллагаа үйлчилгээний талаар иргэд, олон нийтэд ил тод мэдээлэх сурталчлах, түгээх, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн танилцуулга бүхий контент бэлтгэх ажилд 6,200.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	6,200.0					1	6,200.0					
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>1,978,682.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>1,809,602.3</b>	<b>2</b>	<b>169,080.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:											
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Хүний тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>														
Тайлант онд шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 4,688.8 сая төгрөгийн 14 гүйлгээ, орлогын 210,777.5 сая төгрөгийн 13 гүйлгээг хугацаа хоцроон байршуулж, өмнөх аудитаар өгсөн шийдвэр бүрэн хэрэгжээгүй, ижил төрлийн зөрчил давтан гаргасан байна.	1	215,466,395.6								1	1	215,466,395.6		
<b>ДҮН</b>	<b>1</b>	<b>215,466,395.6</b>	-	-	-	-	-	-	-	<b>1</b>	<b>1</b>	<b>215,466,396.6</b>	-	-
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой</b>														
Хүүхдийн мөнгөн тэтгэмжээс e-halamj системээр "хүүхдийн төлөө сан"-д хандив өгөхөөр хүсэлт гаргасан иргэдийн 159,000.0 мянган төгрөгийн мэдээллийг журамд заасны дагуу ил тод мэдээлээгүй.	1	159,000.0						1	159,000.0					
ХХҮЕГ-ын даргын 2025 оны "2025 онд ахмад настанд амралт, сувиллын үйлчилгээ үзүүлэх байгууллагын жагсаалт батлах тухай" А/223 дугаар тушаалын дагуу 24 сувиллын газар, 28 амралтын газартай 2025 оны 06 дугаар сараас 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд гэрээ байгуулж гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байна. ХХҮЕГ-ын даргын 2026 оны 02 дугаар сарын А/52 дугаар тушаалаар 2026 онд ахмад настанд үйлчилгээ үзүүлэх амралт сувиллын газрын жагсаалтыг батлахдаа гэрээ байгуулсан 4 амралтын газар, 5 сувиллын газрыг жагсаалтаас хасаж баталсан нь гэрээний үүрэг зөрчигдөх, талуудын дунд маргаан үүсэх эрсдэлтэй байна.	1	-						1						

Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийгмийн халамжийн үйлчилгээг төрөл бүрээр нь зардалд бүртгэж, тайлагнахаар заасны дагуу ерөнхий журналыг хөтөлж байгаа ч мөнгөн гүйлгээний журналд халамжийн гүйлгээг багцаар нь хийж, хөтөлбөр тус бүрээр тайлагнасан байна. Энэ нь халамжийн сангийн үйлчилгээ нь үйлчилгээ тус бүрээрээ зориулалтын дагуу зарцуулагдаж буй эсэхийг хянах боломжгүй, зардал хооронд шилжүүлэн зарцуулсан байх эрсдэлтэй байна.	1	-			1	-	-	-					
Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааны зардлын төсөвт хяналт шалгалтыг орон нутгийн түвшинд хийхэд шаардагдах дотоод томилолтын зардлыг батлаагүй нь халамжийн хөтөлбөр зорилтот бүлэгт хүрч байгаа эсэхэд Төрийн захиргааны байгууллагаас тавих хяналт алдагдах эрсдэлтэй байна.	1	-					1						
<b>ДҮН</b>	<b>4</b>	<b>159,000.0</b>	-	-	<b>1</b>	-	<b>3</b>	<b>159,000.0</b>	-	-	-	-	-
<b>НИЙТ ДҮН</b>	<b>5</b>	<b>215,625,395.6</b>	-	-	<b>1</b>	-	<b>3</b>	<b>159,000.0</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>215,466,395.6</b>	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1109/А017-5347

Улаанбаатар хот

САГ - 2026/11/НА - СТА - ЗГТС

Зөрчил арилгаж тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу 2022 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгоогүй хүүхдүүдэд нөхөн олгох шийдвэрийг Сангийн яамнаас гаргаж, нийгмийн халамжийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансаар 486,360,000.00 (Дөрвөн зуун наян зургаан тэрбум гурван зуун жаран сая) төгрөгийг олгосноос зарцуулаагүй үлдэгдэл 84,160,000.00 (Наян дөрвөн сая нэг зуун жаран мянган) төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн боловч Сангийн яамны Төрийн сангийн газартай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нэмэлт санхүүжилтийн данснаас улсын төсөвт төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Бауыржан, Нийгмийн халамжийн сангийн санхүүгийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Билэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ

9006109  
ATA16087  
9025081411

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-22.Docx

1526181469



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1110/АД175347

Улаанбаатар хот

САГ-2026/11/НА-СТА-ЗГТС

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, системийн хөгжүүлэлт хийхэд 17,800,000.00 (Арван долоон сая найман зүйн мянган) төгрөгийг зарцуулж, шууд зардалд бүртгэсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 41 дүгээр зүйлийн 41.1-т "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна", 41.1.1-т "энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 6.1-д "аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар бүртгэнэ." гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй,"; 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулалгүй худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Бауыржан, Нийгмийн халамжийн сангийн санхүүгийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Билэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

9006109

СТА11087

9006111

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-22.Docx

1526181471



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1111/А0175347

Улаанбаатар хот

САГ - 2026/11/НА-СТА-ЗГТС

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх 1,707,642,300.00 (Нэг тэрбум долоон зуун долоон сая зургаан зуун дөчин хоёр мянга гурван зуун) төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалтыг зарлахдаа тендерийн баримт бичгийн жишиг шаардлагыг мөрдөөгүй, тендерийн баримт бичигт санхүүгийн чадамжийг "шаардахгүй" гэж тусган худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан заалтуудтай нийцэхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.17-д "тендер шалгаруулалтын баримт бичиг" гэж захиалагчаас тендер шалгаруулалтын нөхцөл, шаардлага, аргачлалыг тодорхойлсон баримт бичгийг"; 15 дугаар зүйлийн 15.1-д "Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.", 16 дугаар зүйл "Санхүүгийн чадавхын шаардлага.", 26 дугаар зүйлийн 26.4-т "Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэх эсэхийг дараах байдлаар хянан үзнэ.", 26.4.1-д "энэ хуулийн 15, 16, 17 дугаар зүйлд заасан чадавхын болон туршлагын доод шаардлагыг хангасан байх"; Сангийн сайдын 2025 оны "тендер шалгаруулалтын жишиг баримт шинэчлэн батлах тухай" А/103 дугаар тушаалын хавсралтын 18-д "Чадавхын болон туршлагын шаардлага", 18.1-д "Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална." гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тендерийн баримт бичгийг хуульд заасны дагуу боловсруулдаггүй, холбогдох хуулийг мөрдөж ажиллаагүй. зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, төрийн албан хаагчийг албан тушаалаас чөлөөлөхдөө холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Бауыржан/, Нийгмийн халамжийн сангийн санхүүгийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Билэгмаа/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1112/АД175347

Улаанбаатар хот

САГ-2026/11/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийгмийн халамжийн үйлчилгээг төрөл бүрээр нь зардалд бүртгэж, тайлагнахаар заасны дагуу ерөнхий журналыг хөтөлсөн ч мөнгөн гүйлгээний журналд халамжийн гүйлгээг багцаар нь хийж, хөтөлбөр тус бүрээр тайлагнасан байна. Энэ нь халамжийн сангийн үйлчилгээ нь үйлчилгээ тус бүрээрээ зориулалтын дагуу зарцуулагдаж буй эсэхийг хянах боломжгүй, зардал хооронд шилжүүлэн зарцуулсан байх эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн тайлагнана", Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2024 оны А/384 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан "Халамжийн сангийн дансны жагсаалт"-тай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Мөнгөн гүйлгээний журналыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу хөтлөөгүй зөрчлийг арилгаж, 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Бауыржан/, Нийгмийн халамжийн сангийн санхүүгийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Билэгмаа/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

9006109  
ATA16087  
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-22.Docx

1526181475



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1113/АД175347

Улаанбаатар хот

САГ-2026/11/НА-СТА-ЗГТС

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 4,688,887,948.00 (Дөрвөн тэрбум зургаан зуун наян найман сая найман зуун наян долоон мянга есөн зуун дөчин найман) төгрөгийн 14 гүйлгээ, орлогын 210,777,507,703.00 (Хоёр зуун арван тэрбум долоон зуун далан долоон сая таван зуун долоон мянга долоон зуун гурван) төгрөгийн 13 гүйлгээг тус тус хугацаа хоцроож байршуулж, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 18.11.4-т "сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх" гэж тус тус заасан нөхцөл бүрдсэн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Нийгмийн халамжийн сангийн санхүүгийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Билэгмаад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ноогдуулж, биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Бауыржан/-д даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ  
А.ЦОГБАЯР  
Б.АРИУНЖАРГАЛ  
Г.ӨСӨХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-26 230

9036109  
ATA16087  
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-22.Docx

1526181477